



Долоо хоног тутмын мэдээ мэдээлэл - Монголын Мянганы сорилтын сан

№3 (7)

2021.05.24

АНУ-ЫН ЭЛЧИН САЙД МАЙКЛ С.КЛЕЧЕСКИ: МОНГОЛ УЛСАД ХЭРЭГЖҮҮЛЖ БУЙ УСНЫ КОМПАКТ ГЭРЭЭ НЬ ТОГТВОРТОЙ БАЙДАЛ, УУР АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙГ ДАВАН ТУУЛАХ ЧАДВАРЫГ НЭМЭГДҮҮЛЭХЭД ЧУХАЛ ҮҮРЭГ ГҮЙЦЭТГЭНЭ



Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас “Уур амьсгал өөрчлөгдөж байна, харин бид?” уриан дор 05 дугаар сарын 17-ноос эхлэн орон даяар цахимаар зохион байгуулсан “Уур амьсгалын долоо хоног”-ийн мэдээллийн арга хэмжээнд АНУ-аас Монгол Улсад суугаа Онц бөгөөд Бүрэн эрхт Элчин сайд ноён Майкл С.Клечески нэгдсэн байна. Тэрбээр Монгол Улсын тогтвортой, цэвэр хөгжлийн төлөө хэрэгжүүлж буй томоохон төсөл хөтөлбөрүүдийнхээ талаар онцлоод, цаашид уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах чиглэлээр идэвхтэй хамтран ажиллахаа илэрхийлэв. АНУ-ын

Мянганы сорилтын корпорацын 350 сая ам.долларын буцалтгүй тусламжаар Монгол Улсад хэрэгжүүлж буй Усны Компакт гэрээ нь тогтвортой байдал, уур амьсгалын өөрчлөлтийг даван туулах чадварыг нэмэгдүүлэхэд чухал үүрэг гүйцэтгэхийг энэ үеэрээ цохон тэмдэглэв. АНУ нь уур амьсгалын өөрчлөлтийн тухай Парисын хэлэлцээрт 2021 оны 2 дугаар сарын 19-нд эргэн нэгдэж орсон явдал нь дэлхийн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилтыг хэрэгжүүлэхэд нэн ач холбогдолтой бөгөөд тус улс хүлэмжийн хийн ялгарлаа 2050 он гэхэд “тэглэх” буюу ялгарал шингээлтийг тэнцүүлэх зорилт тодорхойлсон билээ.

[Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам](#)

УУЛ УУРХАЙН УЛМААС ЭВДРЭЛД ОРСОН 8000 ГА ТАЛБАЙГ НӨХӨН СЭРГЭЭХ АЖЛЫН ХҮРЭЭНД ХАМТАРСАН ШАЛГАЛТУУД ХИЙЖ БАЙНА

“Нөхөн сэргээлт-2024” нэгдсэн арга хэмжээг хэрэгжүүлж, улсын хэмжээнд уул уурхайн улмаас эвдрэлд орсон 8000 га талбайд нөхөн сэргээлт хийлгүүлэх ажил үргэлжилж байна. Засгийн газрын 2017 оны 151 дүгээр тогтоолоор батлагдсан “Бичил уурхайгаар ашигт малтмал олборлох журам”-ын хэрэгжилт хангалтгүй, уул уурхайн машин, механизм, техник, хэрэгсэл ашиглан “бичил уурхайн нөхөрлөл” нэрийн дор тусгай зөвшөөрөл, гэрээ дүгнэлтгүйгээр ашигт малтмалыг хууль бусаар олборлож, улмаар Нарангийн гол, Буянт, Ялбаг, Хорьлоо, Хөшөөт зэрэг голуудын голдирлыг дур мэдэн өөрчлөж, голдирол дотор олборлолт явуулж, суваг, шуудуу татах, хоолой тавих зэргээр их хэмжээний газар нутгийг эвдэн сүйтгэж, нөхөн сэргээлт хийлгүй орхиж, экосистемийн тэнцвэрт байдлыг алдагдуулан, байгаль орчинд хортой нөлөөлсөн үйл ажиллагаа газар аваад байна. Иймд бичил уурхайн нөхөрлөл нэрийн дор хууль бусаар ашигт малтмал олборлож, их хэмжээний талбайг эвдрэлд оруулж орхиж байгаа үйл ажиллагааг таслан зогсоох, урьдчилан сэргийлэх ажлуудыг БОАЖЯ үе шаттайгаар зохион байгуулж, нөхөн сэргээлтийн ажлыг эхлүүлэхээр ажиллаж байна.

[Эх сурвалж: Байгаль орчин, аялал жуулчлалын яам](#)

Д.СУМЪЯАБАЗАР: 19 АЖ АХУЙН НЭГЖИЙН ТУУЛ ГОЛЫН ЭРЭГ ДАГУУ ГАЗАР ЭЗЭМШИХ ЭРХИЙГ НЬ ЦУЦАЛНА



Хан-Уул дүүргийн 17 дугаар хорооны нутаг дэвсгэр Туул голын эрэг дагуу газар олгож, барилга барих нэрээр Туул голын бургасанд аюул учруулж байгаа асуудлаар Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар газар дээр нь очиж ажиллалаа. Туул голын хойд эрэг дагуу 2008 оноос хойш 22 аж ахуйн нэгжид газар олгосон байдаг аж. Үүнээс 19 газар эзэмшигч нь барилгын ажлаа эхлүүлээгүй байгаа бөгөөд зарим барилгын компани шөнийн цагаар их хэмжээний хайрга, дайргыг бургаснууд дээр асгаж, гэмтээж байгаа талаар Нийслэлийн Газар зохион байгуулалтын албаны дарга

А.Энхманлай хэллээ. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч Д.Сумъяабазар хууль, дүрмийн хүрээнд ажиллахгүй байгаа дээрх 19 аж ахуйн нэгж, иргэний газар эзэмших эрхийг нь цуцлах арга хэмжээ авна гэв. Өмнө нь хоёр ч удаа Нийслэлийн Газар зохион байгуулалтын албанаас дээрх газруудад мэдэгдэл хүргүүлсэн байна. Мөн тус газруудын хамгаалалтын бүсийг шинэчлэн тогтоох үүргийг холбогдох албаныханд өглөө.

[Эх сурвалж: Нийслэлийн Засаг даргын Тамгын газар](#)

ТОВЧХОН

- Ховд аймгийн Эрдэнэбүрэн сумын нутаг дэвсгэр Шижигтийн хавцалд, Ховд гол дээр усан цахилгаан станцыг барихаар болж, зураг төслийн ажил дууссан бөгөөд уг усан цахилгаан станцыг барих гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах тендер 2021 оны 5 дугаар сарын 17-ны өдөр нээгдэв. 90 МВт хүчин чадалтай “Эрдэнэбүрэнгийн усан цахилгаан станц” баригдсанаар баруун бүсийн таван аймгийн 4,430 ахуйн нэгж, 5,400 орон сууц, 36,000 гаруй гэр хорооллын хэрэглэгч, нийт 52,000 хэрэглэгчийг дотоодын цахилгаан эрчим хүчээр хангана. [Эх сурвалж: ikon.mn](#)
- Үйлдвэрийн бохир усаа шүүж тунгаалгүй ТӨВ ЦЭВЭРЛЭХ БАЙГУУЛАМЖИД нийлүүлдэг ААН-дэд гэнэтийн шалгалт хийж, бодит байдлыг Улстөрч агентлаг УСУГ-тай хамтран сурвалжилсан байна. [Эх сурвалж: Улстөрч.мн](#)
- УСУГ-ын Дусалхүү подкастынхаа ээлжит дугаарыг “Хэрэглэгчдийн цэвэр, бохир усны шугам сүлжээний ашиглалтад тавих хяналт” сэдвээр хүргэж байна. [Эх сурвалж: УСУГ](#)

УСНЫ СЭДЭВТ ЦАХИМ ХУРЛУУД

- Хот, суурин газрын усны менежментийн асуудлаарх дэлхийн хамгийн том арга хэмжээнүүдийн нэг болох “Сингапурын Олон улсын усны долоо хоног” 2021 оны 6 дугаар сарын 22-ноос 7 дугаар сарын 2-ны хооронд цахимаар зохион багуулагдана. [Эх сурвалж: SIWW](#)